




# МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НАЙРАМДАЛ  
ЦОГЦОЛБОРЫН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/267/СТА-ТШЗ





**YAG**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ОЛОН УЛСЫН ХҮҮДИЙН НАЙРАМДАЛ  
ЦОГЦОЛБОРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

**Аудитын код: САГ-2018/267/СТА-ТШЗ**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах  
хаягаар харилцана уу:**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

САГ-ын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663  
Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: Г.Гүнжидмаа  
Утас: 261885  
Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)

Аудитор: Ж.Болормаа  
Утас: 261885  
Цахим хаяг: [bolormaaj@audit.gov.mn](mailto:bolormaaj@audit.gov.mn)

“Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн


Аудитор: С.Уянга  
Утас: 70110799  
Цахим хаяг: [uyanga.s@mn.gt.com](mailto:uyanga.s@mn.gt.com)

Бүртгэл санхүүгийн мэргэжилтэн:  
Б.Эрдэнэбат  
Утас: 70110799  
Цахим хаяг: [erdenebat.b@mn.gt.com](mailto:erdenebat.b@mn.gt.com)

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо  
Юнескогийн гудамж-31,  
Далай тауэр, 9 дүгээр давхар

## **АУДИТЫН ТАЙЛАН**

- 1: Аудитын гэрчилгээ
- 2: Менежментийн захидал
- 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан



## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ .....	1
2	Аудитын тайлан .....	3
2.1	Оршил.....	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	3
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	4
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	4
2.5	Дотоод хяналт.....	5
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	5
2.7	Шилэн дансны мэдээлэл .....	5
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар .....	5
2.9	Аудитын явцад илрүүлсэн гол алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	6
2.9.1	Мөнгөн хөрөнгийн талаар .....	6
2.9.2	Урьдчилж төлсөн зардлын талаар .....	6
2.9.3	Үндсэн хөрөнгийн талаар .....	6
2.9.4	Материаллаг бус зөрчил.....	7
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд .....	8
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....	8
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	8
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
3	Менежментийн захидал .....	10
3.1	Мөнгөн хөрөнгийн талаар .....	11
3.2	Үндсэн хөрөнгийн талаар .....	11
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төлөвлөгөө гүйцэтгэл .....	12
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	15
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.5	Аудит хийгдсэн төлөвлөгөө гүйцэтгэлийн тайлан .....	18





## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН  
НАЙРАМДАЛ ЦОГЦОЛБОРЫН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  
О.ДОРЖСҮРЭН ТАНАА

2018.02.23 № 06/486  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Олон улсын хүүдийн Найрамдал цогцолборын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 02 дугаар сарын 28

№ 01/12

Улаанбаатар хот

САГ-2018/267/СТА-ТМЗ

Төлбөр буцаан төвлөрүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2017 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Ахлах нягтлан бодогч М.Баярмаагийн мэргэшсэн нягтлан бодогчийн 3 жилийн гишүүний татвар 360.0 мянган төгрөгийг байгууллагын мөнгөөр төлж, зардлаар бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, ийн заалтыг зөрчсөн байна.
- Дэд захирал Д.Гантөгсийн гар утасны төлбөр 195.0 мянган төгрөгийг байгууллагын мөнгөөр төлж, зардлаар бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих ...", гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан 555.0 мянган төгрөгийг буруутай этгээдээр төлүүлэн, Үндэсний аудитын газрын Төрийн сангийн 900000601 тоот дансанд 2018 оны 6 дугаар сарын 30-ны дотор буцаан төлүүлэх;
2. Актын биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын Ерөнхий захирал Д.Доржсүрэн, Ахлах нягтлан бодогч М.Баярмаа нарт үүрэг болгосугай.

АКТЫГ

**ТОГТООСОН:**  
 САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
 ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
 АУДИТОР *[Signature]* Ц.НАРАНЧИМЭГ  
 АУДИТОР *[Signature]* Ж.БОЛОРМАА  
 УЛААНБААТАР АУДИТ КОРПОРАЦИ  
 ХХК-ИЙН АУДИТОР *[Signature]* С.УЯНГА

**ВӨШӨӨРСӨН:**  
 ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НАЙРАМДАЛ  
 ЦОГЦОЛБОРЫН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  
*[Signature]* О.ДОРЖСҮРЭН  
 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
 АХЛАХ НИЯГТЛАН БОДОГЧИЙН  
 ЗӨРЧЛИЙН  
*[Signature]* М.БАЯРМАА

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 28

№ 01/30

Улаанбаатар хот

САГ-2018/267/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2017 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

-2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 8 хоног хоцроосон нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “Төсвийн шууд захирагч ....., жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах албан шаардлага өгөх...” заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Санхүүгийн тайланг хоцроосон холбогдох ажилтанд хариуцлага тооцож, санхүүгийн тайланг хуулиар тогтоосон хугацаанд Үндэсний аудитын газар хүргүүлж хэвших;
2. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын Ерөнхий захирал Д.Доржсүрэн, Ахлах нягтлан бодогч М.Баярмаа нарт үүрэг болгосугай.

АЛБАН ШААРДЛАГЫГ

**ӨГСӨН**  
 САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
 ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
 АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ  
 АУДИТОР Ж.БОЛОРМАА  
 УЛААНБААТАР АУДИТ КОРПОРАЦИ  
 ХХК-ИЙН АУДИТОР  
 С.УЯНГА

**ТОГТООСОН**  
 ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НАЙРАМДАЛ  
 ЦОГЦОЛБОРЫН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  
 О.ДОРЖСҮРЭН  
 АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ  
 М.БАЯРМАА

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
 АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ  
 ЗӨРЧИЛҮЙ  
 САНАЛ ДҮГНЭЛТ  
 УЛААНБААТАР ХОТ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 28

№ 01/31

Улаанбаатар хот

САГ-2018/267/СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2017 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- 492,199.6 мянган төгрөгийн өртөгтэй, 32,813.3 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 18 айлын орон сууцыг Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор нь өөрийн үндсэн хөрөнгөнд бүртгэсэн байгаа нь УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”-ийн шаардлагыг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах албан шаардлага өгөх...” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шийдвэрлэх эрх бүхий байгууллагад хандаж, холбогдох шийдвэрийг гаргуулан асуудлыг шийдүүлэх;
2. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын Ерөнхий захирал Д.Доржсүрэн, Ахлах нягтлан бодогч М.Баярмаа нарт үүрэг болгосугай.

АЛБАН ШААРДЛАГЫГ

**ӨГСӨН**  
 САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
 ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
 АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ  
 АУДИТОР Ж.БОЛОРМАА  
 УЛААНБААТАР АУДИТ КОРПОРАЦИ  
 ХХК-ИЙН АУДИТОР С.УЯНГА

**ТОГТООСОН**  
 ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НАЙРАМДАЛ  
 ЦОГЦОЛБОРЫН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  
 О.ДОРЖСҮРЭН  
 АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ  
 М.БАЯРМАА  
 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
 01 ЗӨРЧИЛГҮЙ  
 САНАЛ ДҮГНЭЛТ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 28

№ 01/32

Улаанбаатар хот

СЭТ-2018/267/СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2017 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Өмнөх оны аудитын зөвлөмжөөр өгсөн “Эй Би Жи Энерго” ХХК-ийн барилгын засвар гүйцэтгүүлэх зорилгоор шилжүүлсэн 37,000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах зөвлөмж хэрэгжүүлж ажиллаагүй, хоорондын тооцоо нийлэхээс татгалзсан байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах албан шаардлага өгөх..., Монгол улсын ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.6-д аудитаар илэрсэн зөрчил түүнийг арилгахад өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын Ерөнхий захирал Д.Доржсүрэн, Ахлах нягтлан бодогч М.Баярмаа нарт үүрэг болгосугай.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР *Ц.НАРАНЧИМЭГ*


АУДИТОР *Ж.БОЛОРМАА*

УЛААНБААТАР АУДИТ КОРПОРАЦИ  
ХХК-ИЙН АУДИТОР

*С.УЯНГА*

ТОГТООСОН

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НАЙРАМДАЛ  
ЦОГЦОЛБОРЫН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  
*О.ДОРЖСҮРЭН*



УЛААНБААТАР ХОТ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас төлбөрсөн албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 28

№ 01/33

Улаанбаатар хот

СРГ-2018/267/СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2017 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- “Энх энэрлийн өргөө” ХХК-аар барилгын засварын 42,150.0 мянган төгрөгийн ажлыг сонгон шалгаруулалтгүй гүйцэтгүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчит хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1 дэх заалт, Засгийн газрын 2013 оны 68 тоот тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд баримтлах журам”-ыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах албан шаардлага өгөх...”, гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа хууль, журмыг мөрдөж ажиллах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын Ерөнхий захирал Д.Доржсүрэн, Ахлах нягтлан бодогч М.Баярмаа нарт үүрэг болгосугай.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР Ж.БОЛОРМАА

УЛААНБААТАР АУДИТ КОРПОРАЦИ  
ХХК-ИЙН АУДИТОР

С.УЯНГА

ТОГТООСОН

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НАЙРАМДАЛ  
ЦОГЦОЛБОРЫН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  
О.ДОРЖСҮРЭН

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
АХЛАХ НИЯГТЛАН БОДОГЧ

М.БАЯРМАА

УЛААНБААТАР ХОТ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас төвшин албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу харилцагч албан тушаалтанд харилцагаа тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

## 2 АУДИТЫН ТАЙЛАН

### 2.1 ОРШИЛ

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын ерөнхий захирал О.Доржсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, зардлыг төсөвлөх, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн тайлагнах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 30-наас 2018 оны 2 дугаар сарын 22-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн аудитор С.Уянга, Бүртгэл санхүүгийн мэргэжилтэн Б.Эрдэнэбат нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 05-ны өдөр Улаанбаатар аудит корпораци ХХК-д ирүүлсэн байна.

### 2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

“Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн А/132 дугаар тушаалаар Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын дүрэм, бүтцийг 150 орон тоотойгоор баталсан байна.

#### Байгууллагын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор нь амрагч хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, Монгол ёс заншил, уламжлал, соёлыг сэргээн хүүхэд залуучуудад өвлүүлснээр гэр бүлийн ёс зүй, харилцаа, үнэ цэнийг нэмэгдүүлэх, эрүүл аж төрөх ёсонд сургах, эх оронч сэтгэлгээтэй болгон хөгжүүлэх, амьдрах арга ухаанд сургах байгаль экологийн хүмүүжил олгох, боловсролтой, эрсдэлийг даван туулах чадвартай дэлхийн иргэн болж төлөвшихөд нь дэмжлэг үзүүлэх зорилготой ажиллаж байна.

Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх ажлын хүрээнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын удирдлаган дор үйл ажиллагаагаа явуулдаг төрийн үйлчилгээний байгууллага юм.

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.


### 2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 9 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 31 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.



Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний

нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл дунд буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “aculous” програм хангамжаар бэлтгэсэн байна.

## 2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Тайлант онд төсвөөс урсгал санхүүжилт 497,038.2 мянган төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 497,038.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 3,366,885.2 мянган төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3,253,741.4 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 318,786.7 мянган төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 329,529.1 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

Нийт 4,182,710.1 мянган төгрөгийн орлого олохоор төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 4,093,321.3 мянган төгрөгийн орлого төвлөрч 4,095,280.8 мянган төгрөгийг зарцуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн “Засгийн газрын агентлаг, төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээний тухай” 501 дүгээр тогтоолын 9 дүгээр зүйлд зааснаар Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборыг 2016 оноос эхлэн үйл ажиллагааныхаа орлогоор өөрийгөө санхүүжүүлэх зарчимд шилжүүлж, ажил, үйлчилгээний орлого, байгууллага, иргэний хандив, буцалтгүй тусламж, хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад эх үүсвэрээс бүрдүүлж байна гэсэн шийдвэр гаргасан байна.

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас авсан санхүүжилтийг өмнөх оны өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулж, байгууллагын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд дэмжлэг болгон зарцуулсан байна.

## 2.7 Шилэн дансны мэдээлэл


Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор нь Монгол Улсын “Шилэн дансны тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) хуудсанд шаардлагатай мэдээллийг бүрэн тавьж ажилласан байна.

## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 9 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 31 нарийвчилсан горим, сорилт гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилтын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.



## 2.9 Аудитын явцад илрүүлсэн гол алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

### 2.9.1 Мөнгөн хөрөнгийн талаар

Байгууллага нь баримтын бүрдэл дутуу нийт 870.7 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг бүртгэсэн, 69 ажил гүйлгээний 44,542.9 мянган төгрөгийг тооцоо үүсгэлгүй шууд зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалт, Сангийн сайдын 2014 оны 249 тоот тушаалаар батлагдсан “Аж ахуй нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын 6.1-ийн дагуу бүртгээгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг мөрдөж ажиллах, Сангийн сайдын 2014 оны 249 тоот тушаалаар батлагдсан “Аж ахуй нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын 6.1-ийн дагуу зардлыг холбогдох тооцооны дансаар дамжуулан бүртгэх талаар зөвлөмж өгөх.

### 2.9.2 Урьдчилж төлсөн зардлын талаар

Өмнөх оны аудитын зөвлөмжөөр өгсөн “Эй Би Жи Энерго” ХХК-ийн барилгын засвар гүйцэтгүүлэх зорилгоор шилжүүлсэн 37,000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах зөвлөмж хэрэгжээгүй ба “Эй Би Жи Энерго” ХХК нь хоорондын тооцоо нийлсэн акт үйлдэхээс татгалзсан байна.


#### Шийдвэрлэсэн нь:

Авлагыг барагдуулах зөвлөмж хэрэгжээгүй тул хууль хяналтын байгууллагад хандаж, шийдвэрлүүлэх талаар албан шаардлага өгөх.

### 2.9.3 Үндсэн хөрөнгийн талаар

1. “Энх энэрэлийн өргөө ХХК-аар гүйцэтгүүлсэн 42,150.0 мянган төгрөгийн барилгын засварын ажлыг Засгийн газрын 2013 оны 68 тоот тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журам”-ын 80,000.0 мянган төгрөгөөс доош ажилд харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт хийх заалтыг зөрчсөн байна.
2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр 49,146.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шинээр худалдан авч бүртгэлд тусгасан.
3. Засгийн газрын “40,000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2007 оны 163 дугаар захирамжаар Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 0.087 га нутаг дэвсгэрт орон сууцны барилга барих эрх олгосон. Үүний дагуу 2006 онд байгууллагын эзэмшлийн газар дээр “ЕАС” ХХК нь 70 айлын 3 орон сууцны барилга барьж, тус цогцолборын ажилчдад 18 айлын орон сууцыг олгох нөхцөлтэй гэрээ байгуулсан. Гэвч 2007 онд тус компанитай эрх шилжүүлэх гэрээ дахин байгуулж, 2009 онд тус 18 айлын орон сууцны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ нь “ЕАС” ХХК-ийн захирал М.Чаминцэцэгийн нэр дээр бүртгэгдсэн байна.

2013 оны аудитын зөвлөмжөөр 492,199.6 мянган төгрөгийн өртөн бүхий 18 айлын орон сууцыг Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын үндсэн хөрөнгөнд бүртгэсэн бөгөөд 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн тайланд 32,813.3 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл тайлагнагдсан нь Санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийн шаардлагыг хангахгүй байна.



Шийдвэрлэсэн нь:

1. Засгийн газрын 2013 оны 68 тоот тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журам”-ыг мөрдөж ажиллах талаар албан шаардлага өгөх.
2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 тоот тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх.
3. Уг орон сууцтай холбоотой асуудлыг шийдвэрлэх эрх бүхий дээд шатны байгууллагад хандаж, шийдвэр гаргуулах талаар албан шаардлага өгөх.

**2.9.4 Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:**

